



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/167

Алтанбулаг

Бүх нийтээр мод тарих арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар тогтоол, "Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 6.3.2, 6.3.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоол "Аймгийн Засаг даргын 2021-2024 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.1, 5.1.2, 5.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн "Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах тухай" А/194 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд "Бүх нийтээр мод тарих арга хэмжээ"-г 2022 оны 05 дугаар сарын 13-15-ний өдрүүдэд иргэд, аж ахуй нэгж, байгууллагыг өргөнөөр оролцуулан зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Х.Отгонжаргал

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Г.Март

(Байгаль хамгаалагч)

Гишүүд:

Ж.Эрдэнэцогт

(Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга)

З.Амарсайхан

(Байгаль хамгаалагч)

Э.Зориг

(1-р багийн Засаг дарга)

Н.Мөнхзул

(2-р багийн Засаг дарга)

Г.Мөнхболд

(3-р багийн Засаг дарга)

3.Хөрс боловсруулах, мод сөөг, таримлыг хамгаалах, услах, арчлах арга, технологийн зөвлөмжийг боловсруулан Байгууллагын дарга эрхлэгч нарт чиглэл өгөхийг Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга (Ж.Эрдэнэцогт)-д үүрэг болгосугай.

4.Мод тарих газрыг сонгон үр тарьц суулгацаар ханган хуваарь, маршрут гарган үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн дарга Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал)-д даалгасугай

ДАРГА



Н. ОТГОНЦОГТ